

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2021 оны 8 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 252**ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ, МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТАЛААР АВАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 23.1.3, 23.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Хөгжлийн банкны дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Татан буулгахаар шийдвэрлэгдсэн “Ди Би Эм ассет менежмент” ХХК, “Ди Би Эм Лизинг” ХХК-ийн үйл ажиллагааг сэргээсүгэй.
3. Энэ тогтоолын 2-т заасан компанийг татан буулгах ажиллагааг зогсоож, үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (С.Наранцогт)-д даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм шинэчлэх, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 1 дэх заалт, “Монгол Улсын Хөгжлийн банкны охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 155 дугаар тогтоолын 1, 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Сангийн сайд Б.ЖАВХЛАН